

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Дархан-Уул аймаг

Огноо: 2025 оны 12 сарын 03-ны өдөр

№	Гэрээний дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 оны төсөв /мян.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Хөрөнгийн эх үүсвэр	Аймгийн Засаг дарга, Тамгын газар болон бусад байгууллагын зүгээс хэрэгжүүлэхэд оролцсон тайлан	Хэрэгжээгүй тохиолдолд шалтгаан, үндэслэл, тайлбар	Хэрэгжилтийн хувь
---	-----------------	-------------------------	--------------------------	------------------	--------------	--------------	---------------	------------------------------	---------------------	-------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------	-------------------

3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.

1	3.1.1.	Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтөлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтөлөлтийг зохион байгуулах.	-	Угийн бичгийн хөтөлөлтийн хувь	2018 оны судалгаага агаар гарсан улсын дундаж үзүүлэлт	Угийн бичгийн хөтөлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна. Угийн бичгийн хөтөлөлтийн хувь нэмэгдсэн байна.	Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо өмнөх онд 20 өрх байсан бол 2025 онд 80 өрх болж 100%-аар нэмэгдсэн байна. Шинээр угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо: 80. Сургалтын тоо: 6 Хамрагдсан иргэдийн тоо: 218			"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн баримт бичгийн хүрээнд "Уг удам-Өв соёл" холбоо НҮТББ-тай хамтран Угийн бичгээ сэргээн дэмжье уриатай 6 удаагийн 3 төрлийн сургалтыг зохион байгуулсан. ССАЖЗГ, Ахмадын хороотой хамтран Монгол хүний ураг угшлаа мэдэж удмаа таних дархлааг батжуулан тогтоох, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Угийн бичиг хөтөлөх арга зүйн" сургагч багш бэлтгэх сургалтыг иргэд болон төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж 8 ахмад, 15 төрийн албан хаагч нийт 22 хүнийг багшаар бэлтгэн чадамжийн гэрчилгээг гардуулсан. Угийн бичиг хөтөлөлтийн аргачлал анхан шатны 5 удаагийн 10 цагийн сургалтад Ахмадын холбооны 50 ахмад, Дархан Төмөрлөгийн үйлдвэрийн 35 ажилтан, Соёл урлагийн салбарын 50 ажилтан, СӨБ-ийн 36 багш ажилчид, 25 Нийгмийн ажилтан, нийт 196 хүнийг хамруулан мэдлэг ойлголтыг олгосон.		100%
---	--------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---	--------------------------------	--------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	------

3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:

2	3.1.2.1.	Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	22,500	1.Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо	2024 онд гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо	Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/122 тоот тушаалаар батлагдсан "Гэр бүлийн боловсрол олгох модуль сургалт"-ын агуулгын хүрээнд 25 сургагч багш бэлтгэж, 26 Хамтарсан багаар дамжуулан гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтад 5680 иргэн, 13 байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийн хүсэлтийн дагуу 325 ажилтан алба хаагчид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн сургалт, "Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга" сургалтад 3654 эцэг эх, Гэр бүлийн өдрийг угтан "10 зурх, 1 тойрог" 3 үе шаттай хөтөлбөрт 26 гэр бүлийн 60 эцэг эх, 30 хүүхдийн хамт сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр зэрэгт нийт 8574 эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2024 онд 47, 2025 онд 75 болж 59.6 хувиар өссөн. Дархан сумын 1, 11, 13, 15-р баг, Орхон суманд 25-60 хувиар буурсан. Төлөвлөгөөний тоо: 1 Хамрагдсан иргэдийн тоо: 8574			Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, ШШГГ, ХГБХХГ хамтран "Тодорхой төрлийн гэмт хэрэг, хүүхдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах сургалтын төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлж, зөрчил гаргаж баривчлагдсан 49 хүнд "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зүй" сэдэвт 62 цагийн албадан сургалтыг зохион байгуулж, зөвлөмж зөвлөгөө, итгэлийн захиасыг гардуулан өгч, Цагдаагийн байгууллагын субъектийн санд бүртгэлтэй болон Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн нийт 39 иргэдийн мэдээлэлд хяналт тавин ажиллаж, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг "Аз жаргалын дасгалжуулагч" ТББ-р гэрээлэн гүйцэтгүүлж, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд бүртгэгдсэн 84 хүүхэд, түүний эцэг эхчүүд болон 102 иргэнд анхан шатны хууль зүйн зөвлөгөө үйлчилгээг хүргэж, мэдээлэл өгсөн.		100%
---	----------	-------------------------------------------------------------------------------------------------	--------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	------

3	3.1.2.2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;		1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь	2024 онд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо	Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна.	Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр, цаг үеийн шинжтэй цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй аян арга хэмжээний талаар цахим орчинд бэлтгэн гаргасан 16 видео, 22 зурагт хуудаст мэдээ мэдээллийг цагдаагийн байгууллагуудын цахим хуудсанд байршуулан иргэдэд түгээж ажилласан. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2024 онд 47, 2025 онд 75 болж 59.6 хувиар өссөн. Дархан сумын 1, 11, 13, 15-р баг, Орхон суманд 25-60 хувиар буурсан. Төмөрлөгийн үйлдвэр 2024 онд гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн дуудлага 7 байсан бол 2025 онд дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй үр дүнтэй байна. Хандалтын тоо: 2830	18.000.0	УТ	Иргэд болон байгууллагын ажилтан албан хаагчдыг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор батлагдсан төлөвлөгөөний хүрээнд Цагдаагийн газар, Хамтарсан багууд, Аз жаргалын дасгалжуулагч ТББ-тай хамтран байгууллага, аж ахуй нэгжийн ажилтан албан хаагч, иргэд олон нийтийг хамруулсан 12 удаагийн сургалт, 2 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар нийт 910 иргэд хамрагдлаа. Дархан Төмөрлөгийн үйлдвэртэй хамтран ажиллах гэрээ байгуулж, "Аав байх урлаг, Ажил-амьдралын тэнцвэртэй байдал, Хүүхэд хамгааллын бодлого, Бүх хайраа гэр бүлдээ зэрэг 6 сэдвээр нийт 5 удаагийн сургалтыг 1036 ажилтанд зохион байгуулж, 2 удаагийн цахим контент хийж 53,200 үзэлт хандалт авсан.		100%
4	3.1.2.3.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох;	ОТХ	Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авсан гэр бүлийн тоо	-	Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж, чанар сайжирна.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан 123 насанд хүрэгч, 370 хүүхэд буюу нийт ганцаарчилсан зөвлөгөөг 493 хүнд үзүүлж, хосын зөвлөгөө-5, олон нийтийн сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сард 1 удаагийн давтамжтайгаар цахим 14 видео контент хийснээр 104.700 удаагийн хандалт авч, олон нийтэд сэтгэл зүйчид хандахыг эмзэг биш, зоригтой алхам гэж хүлээн авах хандлага төлөвшиж, олон нийтийн сэтгэл зүйчид хандаж зөвлөгөө мэдээлэл авах нь ихэссэн үр дүнд үзүүлсэн. Сургалт, нөлөөллийн ажлын хүрээнд "Миний сэтгэл хөдлөл, мэдрэмж" бүлгийн сургалт, Төрсний дараах сэтгэл гутралаас сэргийлэх сургалт, "Хүүхэд бидний толь" Анхаарлыг хөгжүүлэх хөтөлбөр (СОС хотхонд 10 удаа), "10 зурх – 1 тойрог" эцэг эх, хүүхдэд зориулсан хөтөлбөр, "Аав байх нь урлаг", "Ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх" сургалт, "Өсвөр насныхны сэтгэл зүйн онцлог" зэрэг 51 удаагийн сургалтыг 2441 хүнд зохион байгуулсан. Шүүхийн захирамжаар 29 гэр бүлийн 116 гишүүнд оношилгоо дүгнэлт хийж, сэтгэл зүйн явуулын үйлчилгээг нийт 4 удаа 3 сумдаар явж 178 иргэнд сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө үйлчилгээг үзүүлсэн. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Дархан сумын ДСЗТГ-аас 19.8 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлж, лэд дэлгэц байршуулж, гэр бүл рүү чиглэсэн олон талт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60%-аар, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа 55%-р өссөн үзүүлэлттэй байна	5.960.000	УТ	Засаг даргын Тамгын газар ХГБХХГ-тай хамтран "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-т зориулсан хүүхэд багачууд болон тэдний эцэг эхчүүдэд сэтгэл зүйн боловсрол олгох, өөрийгөө илэрхийлэх, сэтгэл хөдлөлөө ойлгох чадварыг дэмжих, мөн өсвөр үеийнхэнд зөв дадал төлөвшүүлэх, эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ харилцах урам өгөх орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хөтөлбөр гарган нийт 85 хүүхэд, эцэг эхчүүдийг оролцуулж, хүүхдийн сэтгэл санааг дэмжих, эцэг эх-хүүхдийн харилцааг бататгах, өсвөр үеийнхний өөрийгөө танин мэдэх чадварыг нэмэгдүүлсэн үйл ажиллагааг зохион байгуулсан.		100%
5	3.1.2.4.	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах;	ОНТ	1.Батлагдсан төсөв-100% 2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх	2024 онд баталсан төсөв	Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18.1.2, 19.1.5, 19.1.6, 19.1.7 -т заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор тэдний аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн тусгай байранд түр хамгаалан байрлуулж, тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах Түр хамгаалах байрны урсгал зардал болох 243.170.042 төгрөгийн төсвийн төслийг аймгийн ИТХ-р хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.	243.170.00	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХГБХХГ Түр хамгаалах байрны урсгал зардал болох 243.170.042 төгрөгийн төсвийн төслийг аймгийн ИТХ-р хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.		100%
НИЙТ												
3.1.3. Хүүхдийн эрхийн талаар:												

6	3.1.3.1.	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;	1.Төлөвлөгөө баталсан эсэх 2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна.	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, аймгийн Цагдаагийн газар, Шүүх, Прокурор, Хүний эрхийн үндэсний комиссын Дархан салбар, аймгийн Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран байгуулсан "Хүүхдээс мэдүүлэг авах өрөө"-г Улсын ерөнхий прокурорын а/01 дүгээр тушаалын дагуу 2025 онд дахин тохижуулж, стандарт журмын дагуу үйл ажиллагаа тогтмолжин гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэргийн гэрч, хохирогч, холбогдогч болсон насанд хүрээгүй хүүхдийг мэдүүлэг өгөхдөө сэтгэл санааны хувьд тайван байх, айж сандрахгүй ярих, улмаар өөртөө хэрэгтэй хамгааллын үйлчилгээг авах боломж, нөхцөлийг бүрдүүлж 65 хүүхдийг мэдүүлгийн ажиллагаанд оролцуулж, хууль ёсны төлөөлөгчөөр хангаж ажиллалаа. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолд заасны дагуу Дархан-Уул аймгийн 18 баг, 3 суманд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар хүний нөөц нэмэгдэж 170 кейстэй ажиллаж, 323 хүүхэд, 209 насанд хүрэгчдэд хамгааллын үйлчилгээг үзүүлэн кейс шийдвэрлэлт 95.8 хувьтай. ХТЗ, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны төлөвлөгөөний хэрэгжилт 99%.	130 сая	ОНТ	2025 онд хууль тогтоомж, хүүхдийн эрхийн конвенцын заалтын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохицуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий аймаг, сумын Хүүхдийн төлөө зөвлөлийг Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг, Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын ХТЗ баталж нийт 130 сая төгрөгийг төсөвлөж, ЕБС-ийн сурагчдын өсөлт хөгжил, дархлаа, оюуны чадамжид эерэг нөлөө үзүүлэх зорилготой "Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүд, хэлтэс, агентлагийн удирдлагуудад нийгмийн харуцлага, удирдлагын манлайлын хүрээнд ЕБС, СӨББ-д "Бүтээлч 1 ажил" санаачлан хэрэгжүүлэх уриалгыг гардуулсан.	100%
7	3.1.3.2.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх;	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь	2024 онд хамрагдсан хүүхдийн тоо	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна.	Хүүхдийн хөгжих эрхийг хангах, оролцоог дэмжих ажлын хүрээнд Хүүхэд хөгжлийн ордны 18 төрлийн дугуйланд давхардсан тоогоор 5746 хүүхэд, номын сангаар 1350 хүүхэд шинээр карт нээлгэн үйлчлүүлсэн. Хичээлээс гадуурх хувийн 86 дугуйлан секцэд сар бүр 3307 хүүхэд хамрагдаж байна. "Дээрлэхэлтийг хэрхэн зогсоох вэ?" рийл цахим орчинд давлагаа үүсгэж хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог нэмэгдүүлсэн 73 үйл ажиллагаанд танхимаар 21,158 хүүхдэд хүрсэн. - Unitel HUB төвөөр дамжуулж 4 төрлийн хөтөлбөрт 330 хүүхэд, сансрын 7 хоног хөтөлбөрт 2465 хүүхэд оролцсон. 2024 онд хөгжлийн үйлчилгээнд 17607 хүүхэд хамруулсан бол 2025 онд 13 төрлийн үйлчилгээнд 17894 хүүхдийг хамруулсан нь 1.6%-иар өссөн. Нийт хүүхдээс хөгжлийн үйлчилгээнд 46 хувь нь хамрагдсан.	УТ 22,8 сая, ОНТ-өөс 51,0 сая төгрөг	УТ, ОНТ	Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 51 арга хэмжээд 8058 хүүхдийг оролцуулж, Хүүхдийн марафонд 2100, "Цахим элч" төсөлд 500, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох "Бидний нандин нас" дэвжээ тэмцээнд 900 хүүхэд, "Бяцхан зүрхний хүсэл" нөлөөллийн арга хэмжээнд 238 хүүхэд хамруулсан.	100%
8	3.1.3.3.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах;	Баталсан төсвийн хэмжээ	2024 онд баталсан төсөв	"Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус орон нутгийн зөвлөл аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 01-А/306 тоот захирамжаар 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн үндэсний сургагч багш "Аз жаргалын дасгалжуулагч" ТББ-ын Б.Баасанжав багштай хамтран ажиллах гэрээ байгуулснаар ЕБС, СӨББ-ын хүүхдүүдийн эцэг, эх асран хамгаалагч, ААНБ-ын 50 эцэг эхийн зөвлөлөөр дамжуулж нийт 53 удаагийн 152 цагийн сургалтыг 2510 хүнд зохион байгуулж, эцэг, эх, асран хамгаалагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ.	10,5 сая	УТ		100%

1,694,894

9	3.1.3.4.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;	1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллага н тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. төг/	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх Зулзагын гол хүүхдийн зусланд 60 хүүхдэд үйлчлэх хүчин чадал бүхий 2 гал тогоо бүхий байрыг "Энсада холдинг" ХК нийгмийн хариуцлагын хүрээнд 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, "Дархан Ус суваг" ХК 24 хүүхдэд үйлчлэх боломжтой цэвэр модон хийцлэлтэй 94 сая төгрөгийн өртөг бүхий халуун усны байрыг иж бүрэн шинээр барьж ашиглалтад оруулж хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүллээ. "Ногоон дархан-2032" дэд хөтөлбөрийн хүрээнд Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 100 ширхэг нарс модны дэмжлэг үзүүлснийг нийтийн эзэмшлийн зам талбай тоглоомын талбайд тарилаа. Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг төрийн 2, хувийн 1, ТӨХК 2, нийт 5 байгууллага хэрэгжүүлж, цалингийн нийт сангийн 1 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд зарцуулсан байна. Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллага Шарын гол ХК бөгөөд орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулж 2-р цэцэрлэгийн урлагийн танхимын тохижилт, сумын хүүхдийн автобусны тулш, сэлбэгийн зардал, сумын 4 цэцэрлэгийн гадна хүүхдийн эко тоглоомын талбай байгуулах, ЕБ-ын 2-р сургуулийн спорт заалны засварын ажлыг хийж хэрэгжүүлсэн.	200 сая	ААНБ	АЗДТГ, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний шийдвэрээр зуслангийн засвар тохижилтын ажлууд хийгдсэн.	100%
10	3.1.3.5.	Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах;	Байр танхимаар хангасан оролцооны байгууллага н тоо	Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна.	Дархан-Уул аймгийн Хүүхдийн зөвлөлийг арга зүй удирдлагаар тогтмол хангаж сум, багийн бүсчилсэн чуулганыг 575 хүүхдэд зохион байгуулсан. Хүүхэд бүрийн санал, санаачилгыг авч, эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн хөгжил, хамгаалал, уур амьсгал, нийгмийн бодлого гэсэн 5 чиглэлд нэгтгэн 14 саналыг аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралд танилцуулж, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнд өргөн барьж цаашид аймгийн бодлого шийдвэрт тусгаж ажиллахыг санал болгосон. Хүүхдийн оролцоогоор дамжуулж бие даасан 12 клубт 933 хүүхэд удирдах зөвлөлд хамрагдаж байна. Хүүхдийн оролцооны "Өсвөрийн эмч" клубийг 26 сургуульд 280 хүүхдийг бэлтгэн шинээр байгуулж, хүүхдийн оролцооны 5 клубийн 13 төрлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хүүхдийн зөвлөлийг арга зүй удирдлагаар тогтмол хангаж "Майхант чуулган", Өсвөрийн парламент, "Хүүхэд-Хайр-Ирээдүй" зэрэг 3 чуулганд 25 хүүхдийг оролцуулсан. Үр дүн: Нийт хүүхдийн оролцоогоор дамжуулж 73 төрлийн үйл ажиллагаанд 21158 хүүхдийг оролцуулж дэмжлэг үзүүлсэн.			Аймгийн хэмжээнд хүүхдийн оролцооны 12 клубт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хурал цуглаан, чуулган зохион байгуулахад 4 байршилд 18 удаагийн арга хэмжээг байр танхимаар хангаж ажилласан.	100%
11	3.1.3.6.	"Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх.	1.Олон нийтийн байцаагчийн тоо 2. Илрүүлсэн хүүхдийн тоо	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна.	"Хараа хяналт-2025" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд нийт 255 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж 671 хүүхдийг хамруулж, эрсдэлийн үнэлгээг 639 хүүхдэд хийснээс өндөр эрсдэлтэй 85, дунд эрсдэлтэй 186, бага эрсдэлтэй 368 хүүхэд бүртгэж 198 хүүхдэд хувийн хэрэг нээж ажиллалаа. 2024 оны мөн үетэй харьцуулбал эрсдэлт нөхцөл дэх шинээр илрүүлсэн 104 өрхийн 234 хүүхэд буюу 2,34%-иар дахин өссөн үзүүлтэй байна. Хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээнд суурилан хамтарсан багийн Хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд үндэслэн хариу үйлчилгээг үзүүлж, 234 хүүхдийг эрсдэлийн программд бүртгэсэн. 2025 онд Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн нийт 364 дуудлага мэдээллийг хаягийн дагуу баг руу шилжүүлж, мэргэжлийн байгууллагад холбон зуучлан кейс нээх шаардлагатай дуудлага мэдээлэлд хамтарсан баг хүүхэд хамгааллын төлөвлөгөө гарган хариу үйлчилгээг үзүүлж байна. Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой дуудлага мэдээллийг ХЭУБ, Цагдаагийн байгууллагад газар дээр нь холбон зуучилж, тулгамдсан асуудалд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.	3,162,505	УТ		100%
НИЙТ									
3.1.4. Хүүхэд хамгааллын талаар:									

12	3.1.4.1.	"Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх;		Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо	Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна.	<p>Дархан-Уул аймгийн Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын нийт 176 байгууллагын Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, байгууллагын дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж, Хүүхэд хамгааллын бодлого боловсруулж, мөрдөн ажиллаж буй 99 байгууллага, Хөдөлмөрийн дотоод журамдаа тусган ажиллаж байгаа 97 байгууллага, Эцэг эхийн зөвлөл байгуулсан 127 байгууллага, үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулсан 98 байгууллага байна.</p> <p>Ажлын байрны уян хатан зохицуулалт, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны гэр бүл, хүүхдэд ээлтэй хүний нөөцийн бодлоготой 130 байгууллага, аж ахуйн нэгж байна. Ажлын байрны уян хатан зохицуулалтад орж ажиллаж байгаа 130 байгууллага аж, ахуйн нэгжийн 4540 албан хаагч байна.</p> <p>Үр дүн: 2025 онд шинээр 3 байгууллага Эцэг эхийн зөвлөлийг байгуулж, нийт 130 байгууллага бодлогыг хэрэгжүүлж, 5 байгууллага хүүхдэд ээлтэй орчныг тохижуулан ажиллаж байна. "Эцэг эхийн зөвлөл" байгуулах боломжтой 10-с дээш хүнтэй 201 байгууллагаас 130 байгууллага, аж ахуйн нэгж буюу 64,6% нь эцэг эхийн зөвлөл байгуулсан.</p>			Аймгийн Засаг даргаас төрийн албан хаагчдыг амралтын өдөр ажиллуулахгүй байх, ЕБС, СӨББ-д суралцагч хүүхдүүдийн эцэг эхчүүдийн дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх чиглэлийг хэлтэс, агентлагийн удирдлагуудад өгч, эцэг эхчүүдийг гэр бүлдээ цаг гаргахыг зөвлөлөө. Хүүхдийн "Мэндэлсэн өдөр"-өөр цалинтай чөлөө олгох уриалгад 98 байгууллага, аж, ахуйн нэгж нэгдэж "Байгууллагын дотоод журам"-д тусган хэрэгжүүлснээр 97 байгууллага аж, ахуйн нэгжийн 1574 хүүхэд хамрагдаад байна. Аймгийн хэмжээнд шинээр 5 байгууллага хөхүүл хүүхэдтэй ажилтан албан хаагч нарт зориулсан тусгай өрөө, буланг тохижуулан ажиллуулснаар төрийн 62, хувийн хэвшлийн 8, нийт 70 байгууллага хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг төрийн 2, хувийн 1, ТӨХК 2, нийт 5 байгууллага хэрэгжүүлж, цалингийн нийт сангийн 1 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд зарцуулсан байна.	100%
13	3.1.4.2.	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх;	450.293	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	<p>ХТУ-108 төвөөс 364 дуудлага мэдээллийг хүлээн авч 361 дуудлага мэдээлэлд 336 хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж 99,1% шийдвэрлэж, хяналтад 3 дуудлага мэдээлэл буюу 0,8% шийдвэрлэх шатандаа явагдаж байна.</p> <p>-Хараа хяналт арга хэмжээгээр 255, 108 утсаар ирсэн дуудлага мэдээлэлд 336, Хөгжлийн бэрхшээлтэй эрсдэлт 20, Түр хамгаалах байраар хамгаалах үйлчилгээ авч байсан 13, нийт гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг 616 өрхөд хийсэн.</p> <p>108-аас ирсэн дуудлага мэдээлэл 123, Хараа хяналт арга хэмжээгээр өндөр, дунд эрсдэлтэй 145 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй эрсдэлт 14 нийт хүүхэд хамгаалал шаардлагатай 282 хүүхдээс 256 хүүхэд буюу 89,5 хувьд хувийн хэрэг нээсэн.</p> <p>Хувийн хэрэг нээсэн 256 хүүхдээс 91 хүүхэд буюу 35,5 хувьд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж кейсийг хаасан. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журмын 9.3 дах заалтын дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас "Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжүүлэх журам"-д заасан нормативыг үндэслэн "Нарны хүүхдүүд" асрамж халамжийн төвд 40 хүүхдийн хоолны хувьсах зардал 170,263,111 төгрөг, хөгжлийн үйлчилгээний 164,425,000 төгрөг, "Дархан-СОС" асрамж халамжийн төвд 45 хүүхдийн хоолны хувьсах зардал 33,396,711 төгрөгийг тус тус олгосон.</p>	385.821.187	УТ		100%

14	3.1.4.3.	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх;	1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв; 2. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь	26.7 хувь	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	8,470,000	УТ	ХЭХЗХ-ны гишүүд 13 байгууллага ХЭХЗХ-ны үйл ажиллагааг дэмжин 2025 оны үйл ажиллагааны тайлангийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр ирүүлэн, хамтран ажиллаж байна.	100%	
15	3.1.4.4.	Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих;	1.Хяналт, шалгалтын тоо, 2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь	-	Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна.	1,330,500	УТ	2025 оны Үндэсний их баяр наадмын "Хурдан морины уралдаан"-ыг Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдад 2025 оны 07 дугаар сарын 03-11-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулагдаж, хурдан морины уралдаанд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын өмсгөл, хэрэгсэл, уралдаанч хүүхдийн даатгал, насны хязгаарт Хүүхдийн эрхийн улсын байцаагч хяналт тавиж, уралдаанд оролцогч хүүхдийн бүртгэлийг цахимаар болон цаасаар бүртгэн ажилласан. Тус 4 сумдын Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд давхардсан тоогоор нийт 345 уралдаанч хүүхэд оролцож цахим бүртгэл хийсэн байна. Уралдааны үед 10 хүүхэд мориноос унаснаас 6 хүүхэд гэмтэл бэртэлгүй, 2 хөнгөн, 2 хүүхэд хүндэвтэр гэмтэл авч эрүүл мэндийн үйлчилгээ, холбогдох даатгалын компаниудад холбон зуучилсан. Мөн хяналт шалгалтын хүрээнд 3 зөвлөмжийг 3 морин спорт уяачдын холбоонд хүргүүлэн ажилласан.	96%	
16	3.1.4.5.	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;	1.Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо	MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага	Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна.	Аймгийн Эрүүл мэндийн газар, ОБГ-аас зохион байгуулсан гамшигийн эрсдлийн үнэлгээ хийх сургалтад 4 албан хаагч анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх сургалтад 1, нийт 5 албан хаагчийг сургалтад хамруулж чадавжуулж, Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан СӨРГӨ-2025 төвийн бүсийн стратегийн команд штабын дадлага сургуулилтад оролцох бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэн, сэтгэл зүйн өртөө ажиллуулсан. Үр дүн: Үйлчилгээ авсан өрхийн тоо - 3, Хүүхдийн тоо - 8	Аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчөс 2.165.00 төг, Дархан сумын ЗДТГ-с 2.000.000 төг, Аймгийн ЗДТГ-аас 3.000.000 төгрөг	ОНТ	Дархан-Уул аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр 25-ны өдрийн 011-/А/479 дугаар бүхий захирамжаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын албыг 5 байгууллагын 48 албан хаагчийн бие бүрэлдэхүүнтэйгээр байгуулж албаны төлөвлөгөө, мэргэжлийн ангийн төлөвлөгөөг боловсруулж Онцгой байдлын газраар хянуулан батлуулсан. Сум, Баг тус бүрт Хүүхэд нийгмийн ажилтантай болсноор гамшиг онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажил сайжирсан. Дархан сумын 3 дугаар багийн 3 өрх нь галын аюулд өртөж орон гэргүй болсонтой холбогдуулан хамтарсан багийг шуурхай хуралдуулж 3 өрхийн 8 хүүхэд Аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчөөс 2.165.00 төг, Дархан сумын ЗДТГ-с 2.000.000 төг, Аймгийн ЗДТГ-аас 3.000.000 төгрөг нийт: 7.165.000 төгрөгийн тусламж үзүүлж орон гэртэй болгож, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ тусламж дэмжлэг үзүүлсэн.	100%

17	3.1.4.6.	Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;		Осол гэмтлийн буурсан хувь		Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна.	Үр дүн: Осол гэмтэл 70 хувиар буурсан.	25.000.000	Улсын төсөв	Дархан-Уул аймгийн ЗДТГ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Захирагчийн ажлын алба, Дархан хотын Тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ, Дархан соёл амралтын хүрээлэнтэй хамтран хяналт шалгалтыг 2025 оны 05 дугаар сарын 06-15 ны өдрүүдэд зохион байгууллаа. Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах 113, Шарын гол сумын 12, Орхон сумын 5, Хонгор сумын 8 нийт 138 нийтийн эзэмшлийн хүүхдийн тоглоомын талбай байна. Үүнээс 73 тоглоомыг Дархан хотын Тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ, 40 тоглоомыг тухайн хорооллын Сууц өмчлөгчдийн холбоо хариуцаж байна. Хүүхдийн тоглоомын талбайд тавих ерөнхий шаардлага MNS6751:2019 стандартын хэрэгжилтийг хангасан 6 тоглоом, хэрэгжилтийг хангаагүй 60 тоглоомын талбай байсныг илрүүлж, хүүхдийн тоглоомын талбай ойролцоо байрлах орон сууцны гэрэлтүүлэг, цахилгааны сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж нийт 130 гаруй зөрчил дутагдлыг илрүүлж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн, шаардлагатай засвар үйлчилгээг хийж, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж хүүхдийн тоглоомын оочинг сайжруулсан.		100%
18	3.1.4.7.	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах.		Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь		Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйл 15.2 дахь заалт, Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015 стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд Дархан-Уул аймагт үйл ажиллагаа эрхэлж буй "Од" хүүхэд харах үйлчилгээний ажлын байранд 2025 онд 2 удаа төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, шалгалтын явцад 4 зөрчил илрүүлж 2 буюу 50 хувийг газар дээр нь арилгуулж, үлдсэн 2 зөрчлийг арилгуулахаар Хүүхдийн эрхийн Улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж ажилласан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 01/728 тоот чиглэл, удирдамж болон "Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS7076:2025" Монгол Улсын стандартын дагуу аймгийн хэмжээнд өдөр өнжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Домбоско-Шинэ үе" НҮТББ, "Гэгээн гэгээ", "Полилот" нийт 3 аж ахуй нэгжид хяналт шалгалтыг зохион байгуулж, нөхцөл байдалтай танилцаж, нэгдсэн бүртгэлд хамруулан судалгаа хийж, өдөр өнжүүлэх төвд тавигдах нийтлэг зүйлсийн дагуу ажлын байранд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн хяналт шалгалтын хүрээнд 1 төвд ХЭУБ-ын албан шаардлага, 2 төвд зөвлөмж хүргүүлэн ажилласан. Үр дүн: Хүүхдийн эрхийн зөрчил 80 хувиар буурсан.	31.001.713	Улсын төсөв	Дархан-Уул аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01-А/208 тоот "Ажлын хэсэг байгуулах тухай" захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд нь хяналт шалгалтыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ээс, 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Шарын гол суманд үйл ажиллагаа явуулж буй зөвшөөрөлтэй 32, зөвшөөрөлгүй 16 нийт 48 сүм хийд, шашны байгууллагуудад хяналт шалгалт хийлээ. Сүм хийд шашны байгууллагаар нийт 648 хүүхэд үйлчилгээ авч, шавилан сууж байгаа 6 ламхай хүүхэд байна. Сүм хийдүүдэд Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, давхардсан тоогоор нийт 42 зөрчил илэрсэн. Зөрчил илэрсэн дээрх аж ахуйн нэгж, байгууллагуудад илэрсэн зөрчил дээр нь Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ тооцон ажилласан.		100%
НИЙТ												
3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;												
3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар:												

19	3.2.1.1.	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах;	2,074,121	Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	Улсын хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан.	ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	Зохистой ажлын байрыг бий болгох, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоол, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Орон нутгийн өмчит 17, барилгын салбарын 91, хувиараа хөдөлмөр эрхлэгч 16, нийт 19 салбарын 124 төлөөллийг оролцуулан "Оффессын ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал", "Үйлдвэрлэлийн осол хурц хордлогоос урьдчилан сэргийлэх", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх", "Орчны хөдөлмөрийн эрүүл ахуйн талаарх асуудлууд", "Хөдөлмөрийн эрхийн маргааны асуудал" сэдэвт сургалт зохион байгуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. "Ажил олгогчийн өдөрлөг-2025" арга хэмжээг зохион байгуулж Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тооцох, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажилтнаа манлайлах хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч 150 байгууллагын 287 албан хаагч хамрагдаж 1,075,000 төгрөг зарцуулсан. Үр дүн: ААНБ-19 салбарын 411 байгууллага Мөнгөн дүн-1,075,000 төгрөг	1,075,000	ХЭДС	Дархан-Уул аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, ажил олгогч эздийн холбоо хамтран оролцсон	100
20	3.2.1.2.	Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;		1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо		Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна.	Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээнд хувийн хэвшлийн 11 байгууллагыг хамруулж, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай, Хөдөлмөрийн харилцааны тухай, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, ажил олгогч, ажилтны хоорондын хөдөлмөр эрхлэлтийн харилцааны зөв соёлыг төлөвшүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч сургалт зохион байгуулж 35,200,000 төгрөг зарцуулсан. Танхимын сургалтыг 3 удаа зохион байгуулж боловсрол, барилгын салбаруудын 45 удирдах ажилтан, 25 албан хаагчдыг хамруулж, 2,950,000 төгрөг зарцуулсан. Үр дүн: ААНБ-57 Сургалтын тоо-3 Мөнгөн дүн-38,150,000 төгрөг	38,150,000	ХЭДС	Дархан сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо	100
21	3.2.1.3.	Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;		Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо	Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо	Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна.	Хөдөлмөрийн Эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо 2025 оны байдлаар 20 өргөдөл гомдлыг хүлээн авч 4 буцааж, 9 эвлэрүүлж, 7 өргөдлийг дараагийн шатны байгууллагад хандах эрхийг нь нээлттэй үлдээж шийдвэрлэсэн байна. Өргөдөл гомдол ирүүлсэн 20 иргэн, 65 ажил олгогч нарт Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн харилцааны талаар сургалт 2 удаа явуулж, 2,700,000 төгрөг зарцуулсан. 2025 онд сонирхлын маргаан гараагүй болно Үр дүн: Байгууллага-65 Мөнгөн дүн-2,700,000 төгрөг	2,700,000	ХЭДС	Дархан сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо	100
22	3.2.1.4.	Аймаг, сумын хамтын хэлэлцээрийн байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах.		Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна.	Аймгийн Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт хорооны 2022-2024 оны хэлэлцээрийн биелэлтийг 93%-ийн гүйцэтгэлтэйгээр дүгнэж, 2024-2026 оны хэлэлцээрийг байгуулж бүртгэсэн. Үр дүн: хамтын хэлэлцээр-1			Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт байгууллагууд	90
НИЙТ											
3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:											

23	3.2.2.1.	2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах;		1. Бодлогын баримт бичгийн тоо, 2. Судалгаа, мэдээллийн тоо	Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагаа ны 2024-2028 оны хөтөлбөр	Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна.	Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын шаардлагатай хөрөнгө оруулалт, дэмжлэгийн судалгааг ЖДҮГ-тай хамтран авч Дархан-Уул аймгаас 510 иргэн, аж ахуйн нэгжийг хамрууллаа. Судалгаанд оролцогчдын 13,7 хувь нь хог хаягдал дахин боловсруулах, 9,7 хувь нь арьс ширэн бүтээгдэхүүн, 8,9 хувь нь сүү, сүүн бүтээгдэхүүн, 7,1 хувь нь төмс, хүнсний ногоо боловсруулах, 7 хувь нь ахуйн үйлчилгээ болон хүлэмжийн аж ахуй, мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, ноос ноолууран бүтээгдэхүүн, малын тэжээл, бордоо, барилгын материалын үйлдвэрлэлийг нэн тэргүүнд дэмжих шаардлагатай гэсэн санал өгснөөс гадна 39,5 хувь нь бага хүүтэй хөнгөлөлттэй зээл, 26,9 хувь нь үйлдвэр, үйлчилгээ явуулах ажлын байр, 26,2 хувь нь татвар, нийгмийн даатгалын хөнгөлөлт шаардлагатай, 26,9 хувь нь санхүүгийн хүртээмж бага, 16,5 хувь нь цалин хангамж хүрэлцээгүй, 16,2 хувь нь сургалт зөвлөх үйлчилгээ дутмаг, 14,1 хувь нь зах зээлийн багтаамж бага байгаагийн улмаас бизнес эрхлэхэд хүндрэлтэй гэсэн байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 16.2 тэрбум төгрөгийн санхүүжилт орон нутагт хуваарилж, хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар нийт 226 төсөлд 29.2 тэрбум төгрөгийн хүсэлт цахимаар ирүүлсэнээс 15.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хөнгөн үйлдвэр 98 аж ахуйн нэгж санхүүжилт авч, 75 ажлын байр хадгалагдан 23 ажлын байр шинээр бий болжээ.				100%
24	3.2.2.2.	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах;	Судалгаа, мэдээллийн тоо	Албан ёсны статистик (Ажиллах хүчний судалгаа) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан(ЕJOB систем)	Аймгийн/сум тус бүрээр/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох зорилгоор ажилгүй, ажил хайж байгаа, зорилтот бүлгийн 14503 иргэний судалгааг захиргааны мэдээлэлд үндэслэн гаргаж, иргэн бүртэй холбогдон тодруулга хийж ажил хайгч, ажилгүй, зорилтот бүлгийн 1458 иргэдийг бүртгэн, зөвлөгөө мэдээлэл өгч, ур чадварын үзүүлэлтийг судалж 500 иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг 500, хувийн төлөвлөгөөг 500 иргэнд хийж Хөдөлмөр эрхлэлтийн EJOB системд бүртгэж 2,400,000 төгрөг зарцуулсан. 50 ажил олгогчийн 1810 байнгын болон түр, улирлын ажлын байрны эрэлт хэрэгцээг тодорхойлж 1410 иргэнийг тохирсон ажлын байранд зуучлан, хоёр талын хэрэгцээнд нийцсэн тусалцаа үйлчилгээ үзүүлэн эргэх холбоо тогтоож 25,000,000 төгрөг зарцуулсан. Үр дүн: Судалгаа, мэдээллийн тоо-2 Мөнгөн дүн-27,400,000 төгрөг	27.400.000	ХЭДС		100	
25	3.2.2.3.	Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2.684.343	1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь 2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь 3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө	Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлт н гүйцэтгэл 2023 он - Ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 59.5%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3%, ажилгүйдлийн түвшин 5.3% 2022 он - ядуурлын түвшин хөдөө 35.6%	Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдоо арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Орон нутгийн хүн амын бүлгүүд (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0-8 насны хүүхдээ асарч байгаа эзжүүд, залуучууд)-ыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд 154 иргэн, 10 нөхөрлөл, хоршоог хамруулж, 1.478.000.000 төгрөгийн дэмжлэг олгож, 339 байнгын ажлын байр бий болсон. Үүнээс: - Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 60 иргэнд 588,000,000 төгрөг олгож, 117 байнгын ажлын байр, - Ахмадын санхүүгийн дэмжлэгт 40 иргэнд 300,000,000 төгрөг олгож, 77 байнгын ажлын байр, - Малжуулах арга хэмжээний санхүүгийн дэмжлэгт 20 иргэнд 160,000,000 төгрөг олгож, 40 байнгын ажлын байр, - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэднийг асарч буй иргэдэд олгох санхүүгийн дэмжлэгт 22 иргэнд 200,000,000 төгрөг олгож, 57 байнгын ажлын байр, - Хоршоо, нөхөрлөлд олгох санхүүгийн дэмжлэгт 10 иргэнд 200,000,000 төгрөг олгож, 42 байнгын ажлын байр, - Аймгийн шилдэг Старт-Ап 2 баг шалгарч 30,000,000 төгрөгийн 50 хувийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг авч 6 ажлын байр тус тус бий болсон. - Ажил олоход хүндрэлтэй 1, хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байгаа 3 аж ахуйн нэгж байгууллагад 23,892,000 төгрөгийн ажил олгогчийн урамшууллыг олгосон. - Ажил эрхэлдэггүй, ажил хайж байгаа, ажилгүйдэлд өртөж болзошгүй, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, зорилтот бүлгийн хөдөлмөрийн насны 173 иргэний сургалтын хэрэгцээний судалгааг гаргаж 89 иргэнийг оёдолчин, үсчин, гоосайханч, хүнд машин механизмын оператор, тогооч зэрэг 5 мэргэжлээр сургаж, чадамжийн гэрчилгээ олгож 36,261,600 төгрөг зарцуулсан. Үр дүн: Хүн тоо: 246 Ажлын байрны тоо: 431 Мөнгөн дүн: 1.538.153.600 төгрөг	1,538,153	ХЭДС		100

26	3.2.2.4.	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах;	1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 2.Холбогдох арга хэмжээний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3.7%, /2023 он/	Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна.	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхолтой 27 иргэнд 227,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 36 байнгын ажлын байр бий болгосон. -Мэргэжил олгох сургалтын бүртгэлийг явуулж 4 долоо хоногийн сургалтад оёдолчин мэргэжлээр 5, тогооч мэргэжлээр 11, хүнд машин механизмын оператор мэргэжлээр 5, нийт 21 иргэнийг хамруулж, чадамжийн гэрчилгээ олгож 8,510,500 төгрөг зарцуулсан. Халамжаас хөдөлмөрт дэд хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөлтөөс 2 иргэнд 9,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 2 байнгын ажлын байрыг бий болгосон. Үр дүн: Хүний тоо: 59 Арга хэмжээ-2 Мөнгөн дүн: 244,510,500 төгрөг	244,510	ХЭДС			100
27	3.2.2.5.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх;	1. Ажилд зуучуулсан иргэний тооны өсөлт 2. Холбогдох арга хэмжээний тоо	-	Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна.	Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 2 хөдөлмөрийн хувийн биржтэй хамтран "job center" төвийг 2025 оны 12 дугаар сарын 8-ны өдөр нээхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төв нээгдсэнээр иргэд ажилд зуучлал, хөдөлмөр эрхлэлтийн талаарх зөвлөгөө мэдээллийг нэг дороос авах боломж бүрдэнэ. 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 500 иргэнд ур чадварын үнэлгээ, хувийн төлөвлөгөө боловсруулж 1410 иргэнийг ажилд зуучилж 25,000,000 төгрөг зарцуулсан. Үр дүн: Иргэн-1410 Мөнгөн дүн-25,000,000 төгрөг	25,000,000	ХЭДС			95
28	3.2.2.6.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих;	1.Хяналт шалгалтын тоо 2.Судалгаа, мэдээллийн тоо 3.Холбогдох арга хэмжээний тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 30.9 мянга /2024 оны 4 улирал/ Цалин хөлстэй ажиллагч 318.9 мян хүн /2023 он/	Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна.	2025 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 87 иргэний 732.000.000 төгрөгийн төслийн үйл ажиллагаа, хэрэгжилтэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Жижиг зээлийг эргэн төлөлтөөс үргэлжлүүлэн олгож болох шийдвэрийг ХХҮЕГ-ын даргын 2025.11.24 өдрийн 01/1974 тоот албан бичгээр ирүүлсэн тул иргэд олон нийтэд зар мэдээллийг хүргэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үр дүн: Хүний тоо -87 Хяналт шалгалтын тоо -2					100
29	3.2.2.7.	Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртөй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;	1.Холбогдох арга хэмжээний тоо 2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ	2023 онд ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 139 хүнийг хамруулж, 721.0 сая төгрөг зарцуулсан	Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна.	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 15-34 насны гарааны бизнес эрхлэгч залуус оролцох боломжтой "Старт-Ап" арга хэмжээг аймаг, бүсийн хэмжээнд зохион байгуулж 83 баг бүртгүүлж 3 хоногийн ментор, 5 долоо хоногийн хурдасгуур хөтөлбөрт хамрагдсан. - Аймгийн шилдэг "Старт Ап"-д 2 багт 30,000,000 төгрөг, Бүсийн шилдэг "Старт Ап"-д 3 багт 52,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, сургалт, зохион байгуулалтын зардалд 23,000,000 төгрөг зарцуулсан. Үр дүн: Арга хэмжээ-2 Иргэн-83 Мөнгөн дүн-105,000,000 төгрөг	105,000.			Ажил олгогч эздийн холбоо, Их дээд, мэргэжлийн боловсролын байгууллагын консерциум, Төвийн бүсийн 3 аймаг, Соёл, урлаг, залуучуудын хөгжлийн газар,	100

30	3.2.2.8.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран	1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан	ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Санхүүгийн дэмжлэг, Жижиг зээл авсан иргэдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, сурталчлан таниулах зорилгоор 7 байгууллагатай гэрээ байгуулж 129 иргэний бараа материалыг сурталчилж 25,400,000 төгрөг зарцуулсан. Үр дүнд нь иргэдийн бараа материалын захиалгын хэмжээ 30%-иар нэмэгдэн 30,645,000 төгрөгний борлуулалт хийгдсэн байна. Үр дүн: Иргэн-129 Мөнгөн дүн-25,400,000 төгрөг	25,400	ХЭДС		100	
31	3.2.2.9.	Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах,	Холбогдох арга хэмжээний тоо	2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл 2025 оны 1 дүгээр улиралд хуралдаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж 2024, 2025 онуудад санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 6 төсөлд хяналт тавьж ажиллалаа.	-	-		90	
32	3.2.2.10	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах.	1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо	2023 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.	Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-т заалт хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг 7 байгууллага 82,104,000 төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлсэн. Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 40 ахмад настан хамрагдаж 300,000,000 төгрөгийг олгож 77 ажлын байр бий болсон байна. Үр дүн: Төвлөрүүлсэн хөрөнгө-82,104,000 төгрөг Ажлын байр-77 Зарцуулсан мөнгөн дүн-300,000,000 төгрөг	82,104	ХЭДС		100	
НИЙТ											
3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:											
33	3.2.3.1.	Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх.	2024 оны хэрэгжилт	Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна.	Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан "Хиймэл оюун ухааны хэрэглээ ба цахимжилт" уриатай "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2025" үйл ажиллагааг зохион байгуулж 306 аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагууд, ажилтан албан хаагчдад, 881 иргэдэд Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль мөн салбарын хууль, дүрэм, журмыг баримтлан ажиллах тухай мэдээлэл, зөвлөгөө өгч, 2492 гарын авлагыг 5 төрлөөр тарааж 5,000,000 төгрөг зарцуулсан. -"Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилчдын дурсгалыг хүндэтгэх өдөр"-ыг тохиолдуулан 18 аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч болон албан хаагчид хойчийн буяныг үйлдэж хүндэтгэл үзүүлсэн. -ХАБЭА-н аймгийн салбар зөвлөл нь хоол үйлдвэрлэлийн салбарын 14, шатахууны түгээх станц 10, орон нутгийн өмчийн 16, дугуй засварын 12, нийт 52 аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулсан үзлэг, хяналт шалгалт явуулж Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Үр дүн: Хүн тоо 881 Байгууллага: 376 Мөнгөн дүн-5,000,000 төгрөг	5,000			100

34	3.2.3.2.	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв 2.Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2024 оны гүйцэтгэл	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдад өдөрлөг арга хэмжээг 2 удаа, сургалт арга хэмжээг 3 удаа зохион байгуулж албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч 881, тариаланч 90, малчин 74, нийт 1045 иргэдэд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар мэдлэг мэдээлэл өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Үр дүн: Хүн тоо-1045 Арга хэмжээ-5				100
35	3.2.3.3.	Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо	2024 оны гүйцэтгэл	Тухай бүр арга хэмжээ авсан байх	Тайлант хугацаанд 19 аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн ослын актыг хянан баталгаажуулж, 4 ослын дуудлагын дагуу цагдаагийн болон прокурорын газартай хамтран ажиллаж, бүх ослын актыг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бүртгэх https://inspection.hudulmur-halamj.gov.mn/ сайтад бүрэн бүртгэсэн.				100
НИИТ											

3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар:

36	3.2.4.1.	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ 3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт	2024.12.15 байдлаар: Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 8.1 мянган хүн	Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	E-job программд 31 аж ахуйн нэгж байгууллагын 80 ажлын байранд 341 иргэнийг гадаад улсаас авч ажиллуулах хүсэлтийг бүртгэгдсэн. Тайлант хугацаанд ажил хөдөлмөр эрхлэхээр 14 байгууллагад 130 гадаад иргэд ажиллаж байна. Гадаад улсаас ирсэн ажилтныг Монгол улсын иргэнийг дагалдуулан сургаж авах, хөдөлмөр эрхлэх боломжийг олгох ажлын байранд хэт өндөр шаардлага тавихгүй байх зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Үр дүн: Байгууллагын тоо-14, Иргэн-130				100
37	3.2.4.2.	Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт		Хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтын хэрэгжилтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, холбогдох хяналтын хуудсаар эрсдлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг тогтоож, гадаад улсын иргэдийг хүн худалдаалах болон албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 15 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийсэн. Үүнээс: боловсролын чиглэлийн 5 аж ахуйн нэгж, төмрийн хүдэр боловсруулах, баяжуулах чиглэлийн 5 аж ахуйн нэгж, барилга угсралтын чиглэлийн 2 аж ахуйн нэгж, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 аж ахуйн нэгж байгууллагад 143 гадаад иргэн ажиллаж байна Үр дүн: Байгууллага-15, Иргэн-143				100

НИЙТ											
3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.											
3.3.1. Нийгмийн даатгалын талаар:											
38	3.3.1.1.	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн	1,835,146	Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь	Аймгийн хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2024 онд 5032	Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар 503 даатгуулагчаар нэмэгдүүлсэн байна.	Жилийн эцсийн байдлаар 520 сайн дурын даатгуулагч шинээр хамруулж төлөвлөгөө 100% биелсэн.			Жилийн эцсийн байдлаар нийт 520 даатгуулагч шинээр хамруулсан. Үүнээс: энгийн сайн дурын даатгалд 256, малчин 70, 0-03 насны хүүхдээ асарч буй эх 103, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил эрхлээгүй эцэг эх 91 иргэний сайн дурын даатгалд хамруулж төлөвлөгөөг 100% биелүүлсэн байна.	100%
39	3.3.1.2.	Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;		Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь	"Ухаалаг архивын систем" төсөл 2022 онд хэрэгжсэн.	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	Аймгийн хэмжээнд 18319 тэтгэвэр авагчдын санхүүгийн анхан шатны баримтын аюулгүй байдал бүрэн хангагдсан.			Ухаалаг архивын систем нэвтрүүлэх ажлын хүрээнд НДХ-ийн даргын 2022 оны 1 дүгээр сарын 14-ны өдрийн А/02 дугаар тушаалаар тэтгэврийн хувийн хэргэ цахимжуулах ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 18319 тэтгэвэр авагчтай, 2025 оны жилийн эцсийн байдлаар шинээр тогтоосон 1285 тэтгэвэр авагчдын хувийн хэргийг бүрэн цахимжуулан ажиллаж байна.	100%
40	3.3.1.3.	Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;		Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	2024 оны жилийн эцсийн тайлангаар төсөвт байгууллагын 667566.9 мян төг өр үүсгэсэн.	Төсөвт байгууллагын өрийг бүрэн барагдуулсан байх.	667032.7 мян төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулсан.			Энэ онд төсвийн 4 байгууллагын 667032.7 мян төгрөгийг бүрэн барагдуулсан. Төсвийн алба нь 2017 онд татан буугдсан тул үлдэгдэл авлага 534.2 мянган төгрөгийг НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газарт уламжлан барагдуулах хүсэлт хүргүүлсэн ч шийдэгдээгүй байна. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу шалтгааны улмаас 2025 оны жилийн эцсийн байдлаар ХБГ-ээр аймгийн Нэгдсэн эмнэлэг-1,299,198.9 мян төгрөг, Шарын гол Эрүүл мэндийн төв 81,456.7 мян төг өр үүсгэхээр байна.	100%
41	3.3.1.4.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;		Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо	Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 102446	Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна.	Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог бууруулахаар урьдчилан сэргийлэх 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан.			Дархан-Уул аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 3550 байна. 2025 оны 04 сарын 10-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран зорилтот бүлгийн 116 иргэдтэй уулзалт зохион байгуулж, сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Дархан-Уул аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон 2013 иргэдийг аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх ЭММЗ-ийн магадлагч эмч, нарийн мэргэжлийн гишүүн эмч нар 2025 оны 06 дугаар сар, 11 дүгээр сарын 5-наас 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд хуваарийн дагуу Аминхолобоо ӨЭМТ, Түвшинхолобоо ӨЭМТ, Госхот ӨЭМТ, Мэдс Тоб ӨЭМТ, Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр 2 удаа дахин магадлал хийж ажиллалаа. Дахин магадлалын үр дүнд: •Өвчний заалт өөрчилсөн -51 •Хувь бууруулсан - 44 •Цуцалсан - 100 •Хэвээр магадласан - 1818	100%

42	3.3.1.5.	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаагаар болсон байна.	Энэ онд иргэд даатгуулагчдад мэдээ мэдээлэл өгч, сурталчилан таниулах ажлыг зохион байгуулав.			Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд шаардлагатай судалгаа мэдээ мэдээллийг тухай бүр гарган хамтран ажиллаж байна.	100%
НИЙТ											

3.3.2. Нийгмийн халамжийн талаар:

43	3.3.2.1.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо	-	Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна.	Байнгын асаргаа шаардлагатай ХБИ, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх, эдгэршгүй хүнд өвчтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх ДААХХҮГ/20250203004/01/01 тоот тендэр, Олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнд үйлчилгээ үзүүлэх ДААХХҮГ/20250203006/01/01 тоот нийт 93,9 сая төгрөгийн өртөг бүхий тендэрийг тус тус зарласан. Тендэрийн үр дүнд "Итгэлт мөрөн ХХК" 55,0 сая төгрөг, "Мөнгөтийн таг" ТББ 38,9 сая төгрөгийн ажил, үйлчилгээ үзүүлэхээр шалгарсан тул 2025 оны 7 дугаар сарын 25-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний гүйцэтгэлээр 1.Итгэлт мөрөн ХХК -Байнгын асаргаа шаардлагатай ХБИ-134, -Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх-82, -Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан-128 хүнд үйлчилгээ үзүүлж 39.230,000 төгрөгийн санхүүжилт олгосон. 2.Мөнгөтийн таг ТББ: -Олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх-87 -Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 56 өрх иргэнд үйлчилгээ үзүүлж, 26.500.00 төгрөгийн санхүүжилт олгосон. Үр дүн: Хүний тоо-487, Мөнгөн дүн -65.730.000 төгрөг	65.73	ОНТ		70
44	3.3.2.2.	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтлоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо	-	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтлоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Орон гэргүй архины хамааралтай иргэдийг нийгэмшүүлэх, донтлоос ангижруулах зорилгоор "Жаргалтай амьдрал" ТББ-тай хамтран архины хамааралтай 173 иргэнийг эмийн болон сэтгэл заслын эмчилгээнд хамруулж, архинаас татгалзах нийгэмд тустай ажил хөдөлмөр эрхлэх сургалтад хамруулсан. Огт архи хэрэглээгүй иргэн 63-64% тай байна. Жаргалтай амьдрал төвд архины хамаарлаас гаргах нөхөн сэргээх эмчилгээ хийлгэж, хэвтэн эмчлүүлсэн 10 иргэнийг Оросын Холбооны улсын Улан-Үд хот руу донтолтын эсрэг эмчилгээнд хүргэн өгч кодлох, тарилга хийлгүүлэх ажлыг зохион байгуулсан. Орон нутгийн төсвөөс 248.700.000 төгрөг зарцуулсан. Үр дүн: Хүний тоо- 183 Мөнгөн дүн-248.700.000 төгрөг	248.7	ОНТ		100
45	3.3.2.3.	Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадваржуулах сургалтад тогтмол хамруулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо,	-	Нийгмийн ажилтнуудын мэдлэг ур чадвар сайжирсан байна.	Албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан чадваржуулах сургалт болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, аймгийн Засаг даргын тамгын газар, Боловсрол шинжлэх ухааны газар болон мэргэжлийн сургалтын байгууллагууд, Төрийн бус байгууллагуудтай хамтран танхим, болон цахимаар зохион байгуулсан 40 удаагийн 312 цагийн сургалтад давхардсан тоогоор байгууллагын 60 албан хаагчийг хамруулж, мэргэшүүлэх, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан		ТББ		100
НИЙТ											

3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тааар:

46	3.3.3.1.	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;	1,304,664	Сургалт	-	30-аас доошгүй	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Засгийн газрын 253-р тогтоолын хэрэгжилт дэд бүтцийн хүртээмж стандарт, хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт мэдлэгийн талаар Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж 48 байгууллагын 450 иргэнд мэдээлэл өгч сургалт зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Үр дүн: Хүний тоо-450				100%
47	3.3.3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	20	2024 оны УИХ сонгууль, 2024 оны 10 сарын орон нутгийн сонгууль, 2025 оны багийн Засаг дарга нарыг сонгох сонгуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөр үйлчлүүлдэг нэн туслалцаа хэрэгтэй 42 иргэнийг төвийн ажилчид машинаар зөөвөрлөж, туслалцаа үзүүлсэн.				100%
48	3.3.3.3.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах;		Зохион байгуулсан сургалтын тоо	-	3	2025 онд ХБХХТөв нь ахмад мэргэжилтэн Д.Оюунсүрэн эмчтэй хамтран гэрийн асаргаанд байдаг, хэвтрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ гэрийн үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүнд: 1. Өсвөр насныханд бэлгийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн ариун цэвэр сахиу тухай сургалт зохион байгуулсан. 2. Хэвтэрт байгаа өсвөр үеийн хүүхдийг усанд оруулах, арьс арчилгааны талаар сургалт хийсэн. Арьсны нуруул, холголт, цооролтоос хамгаалах тохиромжтой тосыг зөв сонгож хэрэглэх зөвлөгөө өгч ажилласан. 3. Өсвөр үеийнхний хооллолтын зөвлөгөө сургалтын багцыг хэрэгжүүлснээр биеийн жингийн индексийг хэвийн байлгах талаар сургалт зохион байгуулсан. Мөн өсвөр үеийнхний дунд түгээмэл тохиолддог хооллолтын эмгэг үүсгэдэг айдас түгшүүрийн талаар ярилцсан.				100%
49	3.3.3.4.	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төвийг байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Дэмжих төв	-	1	Дархан-Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгт өргөтгөлөөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, асаргаа, халамж хамгаалал, хөгжил, боловсролын үйлчилгээ үзүүлэх барилгын өргөтгөлийг барьж, улсын комисс хүлээн авсан.				100%
50	3.3.3.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	2	Орон нутгийн төсвөөс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааны зардалд 5,000,000 төгрөг баталсан. Нандин зурх" НҮТББ-тай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй оюуны хоцрогдол, уналт таталт, саа саажилттай 54 хүүхдийг УБ хотын ЭХЭМҮТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулсан. Орон нутгийн төсвөөс унааны хөнгөлөлт үзүүлсэн.	5,000,000	ОНТ		100
51	3.3.3.6.	Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100	Гамшгаас хамгаалах, хүн ам, нийгмийн хамгааллын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй 4571 иргэний мэдээлэл, тоон судалгааг Онцгой байдлын газарт хүргүүлсэн. Онцгой байдлын үед авах арга хэмжээг Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, Ахмад настныг болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хэрэгцээ шаардлагыг тусган гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн.				100

52	3.3.3.7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	5	Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй 230 эцэг, эх асран хамгаалагчдад Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Нийгмийн халамжийн тухай хууль холбогдох дүрэм журмын талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. ХБХЭЭХ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран 61 эцэг эх, асран хамгаалагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний онцлог, туслах хэрэгсэл ба тохируулгат хэрэглэгдэхүүн, ялгаатай байдлын талаар сургалт зохион байгуулсан. БСУГ-тай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад багш, эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагаа" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, ЕБС-ын дэмжлийн багийн 28 гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 12 эцэг эхийг хамруулсан. Үр дүн: Хүний тоо 406			Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/68, А/62 дугаар хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Дархан- Уул аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран Эмнэлэг хяналтын комисс, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн удирдлага, эмч нар, хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан баг сумын мэргэжилтнүүд нийт 75 албан хаагчдад байнгын асаргааны тэтгэмж олгохтой холбоотой гарч буй хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, тухайн асуудлаар харилцан ойлголцолд хүрч, салбар хоорондын уяалдаа холбоог сайжруулж, эрсдэлээс сэргийлэн зөвлөмж гарган хүргүүлсэн.	100
53	3.3.3.8.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо	-	3	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд: 25 ба түүнээс дээш ажилтантай 171 аж ахуй нэгж байгууллагын ажил олгогчид, олон нийт нийт 440 иргэдэд хуулийг сурталчлан таниулж, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-т заалт хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг 7 байгууллага 82,104,000 төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлсэн. Үр дүн: Хүний тоо-440 Төвлөрүүлсэн хөрөнгө-82,104,000 төгрөг	82,104,000	ОНТ		100
54	3.3.3.9.	Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо	-	5	RGB телевизтэй хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагааг СӨРӨГ бус ЭЕРЭГ уриантайгаар нээлтийг хийж зохион байгуулсан. Дархан-уул аймгийн ЗДТГ-ийн хэвлэл мэдээллийн алба, СУАЖЗГ-тай ХБХХТөв хамтран ХБИ-ийг соён гэгээрүүлэх хөтөлбөрийн хүрээнд DBS TV - Төвийн бүсийн телевиз, Дархан-уул аймгийн анхны видео сайт болох Цэц.мн, Шинэ цэнхэр дэлгэц өсвөрийн сэтгүүлчдийн холбоо зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан ХБХХТөвд зохиогдож буй арга хэмжээг сурталчлан олон нийтэд мэдээллэж байна. Үүнээс онцолбол: Шинэ цэнхэр дэлгэц өсвөрийн сэтгүүлчдийн холбоотой хамтран -Нил ягаан өдөр /Эпилепси/ -Аутизмыг таниулах өдөр - Дауны хам шинжийг таниулах өдрүүдийн талаарх 3 цуврал видео контентыг санаачлан зохион байгуулсан. Мөн ХБХХТөвийн цахим хуудсаар дамжуулан хүүхдийн хөдөлмөр засалч Ө.Өлзийжаргалын 41 удаагийн богино хэмжээний рийл бичлэг хийж байршуулсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний эцэг эх асран хамгаалагчдад хүрч талархал хүртээд байна. БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА сэдэвт 7-н цуврал рийл бичлэг хийж төвийн цахим хуудсанд байршуулсан.				100%

55	3.3.3.10	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Эрхэм нандин сувд" ТББ-аас санаачлан зохион байгуулж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нарын мэргэжлийн эмч нарын 6 дах удаагийн нэгдсэн үзлэг, оношилгоонд Дархан-Уул аймгаас хамрагдах 41 хүүхдийн бүртгэлийн хураамж, унааны зардалд 1.6 сая төгрөг зарцуулан Эх нялхас эрүүл мэндийн төвд автобусаар хүргэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үзлэг оношилгоонд хамруулан ажилласан. Олон улсын эрдэм шинжилгээний чуулганд оролцох Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 5 мэргэжилтний сургалтын төлбөрт 800,000 төгрөг зарцуулан, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэв. Монгол Абилимп 2025 Улсын уралдааны зардалд 10,000,000 төгрөг, "Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөрт зориулсан спорт тэмцээн"-ны зардалд 8,415,000 төгрөг, Нил ягаан өдөрлөгт 640,000 төгрөг, "Darkhan anti bus tour" өдөрлөгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нэг өдөр төрийн багууллагуудыг үйл ажиллагаатай танилцуулахад зориулж 45 хүний суудалтай автобусаар үйлчлэхэд 300,000 төгрөгийг ОНТ-өөс гарган шийдвэрлэсэн.	21,755	ОНТ		100%
56	3.3.3.11	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв	-	3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9,10 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах талаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтран нийт 11 байгууллаг, 20 замын тэмдэг тэмдэглэгээ, явган хүний гарцын стандартад хяналт тавьж, зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн Засаг Даргын тамгын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн зөвлөлтэй хамтран 25-с дээш ажилтантай 110 байгууллагад дэд бүтцийн хүртээмж хүний эрхийн талаар зөвлөгөө зөвлөмж хурауулан ажилласан.				100
57	3.3.3.12	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах.		Хөгжлийн төвийн тоо	-	1	ХНХЯ, АХБ-ны МОН48706-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн бүтээн байгуулалтын хүрээнд түгээмэл загвар бүхий ХБХХТ-ийн барилгыг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын комисс ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр болсон төвийн нээлтний үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүд, орон нутгийн удирдлагууд, АХБ-ны төлөөлөл, ХБИ-дийн төлөөлөл оролцсон. ХНХЯ Сайдын 2022 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн А/159 тоот тушаалаар 30 хүний орон тоотой баталж байсан. 2024 оны төсөвтэй холбоотойгоор 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.				
НИЙТ											

3.3.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:

58	3.3.4.1.	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Сургалт, мэдээллийн тоо 2.Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо	-	5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хамтран Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/122 тоот тушаалаар батлагдсан "Гэр бүлийн боловсрол олгох сургалтын модуль"-ийн агуулгын дагуу "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалт"-ыг 84 иргэн нийт 3775 хүнд сургалт нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэлээ.				100%
НИЙТ											

3.3.5. Ахмад настны талаар:

59	3.3.5.1.	Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил 2	-	Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна.	Аймгийн хэмжээнд ахмад настны хууль суртчилах сургалт мэдээлэлийг 158 удаа зохион байгуулж 10.906 ахмад хамруулан ажилласан. Үр дүн: Хүний тоо 10.906 Сургалт сурталчилгааны тоо: 158			"Ахмад настны тухай хууль"-ийн нэмэлт, өөрчлөлтийн талаар Дархан-Уул аймгийн Ахмадын хороотой хамтран сум, багийн ахмадын хороодын удирдах зөвлөлийн гишүүд нийт 10354 ахмад амьжиргаа дэмжих зөвлөлийн 154 гишүүнд ахмад настны шинэчлэгдсэн хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.-"ХАБ-ын сарын аян", "Төсөл хөтөлбөр-2025" өдөрлөг, арга хэмжээнд Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 320 ахмад настан, иргэдэд мэдээлэл хүргэж, гарын авлага тараасан. Ахмадын хөгжлийн төвтэй хамтран " Хуулийн мэдлэгээ дээшлүүлэе" аяны хүрээнд 78 ахмадуудад Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг сурталчилж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.	100%
60	3.3.5.2.	Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо, 2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Ахмадын сан байгуулсан ААНБ-ын тоо, тэтгэвэр бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоо	ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна.	- Ахмадын хороотой хамтран 970 төсөвт байгууллага болон Аж ахуйн, нэгж байгууллагатай ахмадын сан байгуулах, 89 төсөвт байгууллага болон Аж ахуйн, нэгж байгууллагатай тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийн талаар зөвлөн тусалж, мэдээллээр байгууллагын удирдлага, ажилтнуудад мэдээлэл хүргэлээ. Аймгийн хэмжээнд тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийн сургалтанд 259 хүн хамрагдсан байна Үр дүн: Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо-54, Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо 9				100%
61	3.3.5.3.	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Баталсан төсвийн хэмжээ /сая.төг/ 2.Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо	Нийт ахмадын 60%	20 -оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна.	Аймгийн хэмжээнд 32 ахмадын ордон өргөө байна үүнд тогтмол үйл ажиллагаа явуулж 9300 гаруй ахмад хамрагдсан / оюун ухаан сэргээх тоглоом,спортын наадгай уралдаан тэмцээн тогтмол явагддаг Багууд ахмадуудыг ая тавтай орчинд чөлөөт цагаа өнгөрөөх орчин нөхцлийг бүрдүүлж хамтран ажиллаж байна. Байртай болсноор Ахмадын зөвлөлийн дарга багийн ахмадуудтай уулзах боломж бололцоо бүрдсэнээр ахмадуудын баг болон ахмадын зөвлөлтэй зөвлөлийн дарга нар ахмадын байрандаа болон уулзаж байгаа ахмадуудаа "Ахмад настны тухай хууль, үндэсний чуулган"-ы зөвлөмжийг сурталчлах болон нийт үйлчилгээнд 4879 ахмад настан хамрагдсан байна. Аймгийн ИТХТ нар 4 багийн зөвлөлийн байранд засвар үйлчилгээ хийж үйл ажиллагаа явуулах боломж нөхцөлөөр хангасан Зарцуулсан төсөв: 26 730 000	26730	ОНТ		100%
62	3.3.5.4.	Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	2024 онд 13123 ахмад настанд 84012 үйлчилгээг үзүүлсэн.	-	Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 102 тоот тогтоолоор "Ахмадын хөгжлийн төв ОНГААТУГ-ыг байгуулж, 2021 оны 9 дүгээр сараас албан ёсоор үйл ажиллагааг эхлүүлсэн. 2025 онд "25625 ахмад настанд 110831 үйлчилгээг үзүүлсэн. Үүнд: 5 өдрийн багц үйлчилгээ, 1 өдрийн багц үйлчилгээ, өдөр бүрийн үйлчилгээ үзүүлдэг.	1,093,020	ОНТ		100%
63	3.3.5.5.	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо	-	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна.	Аймгийн хэмжээнд ахмад настны хууль суртчилах сургалт мэдээлэлийг 158 удаа зохион байгуулж 10.906 ахмад хамруулан ажилласан. Үр дүн: Хүний тоо 10.906 Сургалт сурталчилгааны тоо: 158				100%

64	3.3.5.6.	Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо	Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна.	2025 оны Засаг даргын 01-А/371 дугаар захирамжаар Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан. Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг дэмжих орон нутгийн мэргэжлийн хамтарсан багаас хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.				100%
65	3.3.5.7.	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Бүх шатны боловсролын байгууллага д сургалт хийсэн ахмад настны тоо 2.Ажиллаж байсан байгууллага даа сургалт хийсэн ахмад настны тоо	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	Дарханчууд залилуулахгүй аяны хүрээнд Ахмадын хорооны ажлын алба 1-18 багийн ахмадын дарга нар ахмадууд болон нийт 1919 ахмадууд болон иргэдэд зөвлөгөө өгч 306 ш гарын авлага зөвлөмж тараасан. Ахмад мэргэжилтний ажил хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэх, эзэмшсэн мэдлэг, ажлын туршлагыг залуу хойч үеийхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг сургалт, ментор дадлагын хэлбэрээр зохион байгуулж 42 төслийн 55 ахмад настныг зөвлөх үйлчилгээнд хамруулж, 49,905,000 төгрөгийн урамшуулал олгосон. Ахмадын холбоо, төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээнд Аймгийн ахмадын хороо "Угийн бичиг" төслөөр оролцож сайн дурын ажилтан 11, сургагч багшаар 15 ахмадыг бэлдэж гэрчилгээ олгож, 4 сумдын иргэд 11 төрийн болон төрийн өмчит байгууллагын ажилтан албан хаагчид нийт 1442 иргэнд угийн бичгийн сургалт зохион байгуулж 20,000,000 төгрөг зарцуулсан. Үр дүн: Хүний тоо: 70 Мөнгөн дүн-69,905,000 төгрөг	69,905,000	ХЭДС	Ахмадын настны эрхийг хамгаалах, цахим болон бие сэтгэл зүйн хүчирхийлэл, эрх зүйн мэдлэг олгох сургалтыг төрийн цахим үйлчилгээний мэргэжилтэн 2 удаа 46 ахмадад, аймгийн эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Тэгш оролцоо - тэгш хөгжил" жендерийн тухай ойлголт сургалт, уулзалтыг 18 удаа 366 ахмадууд оролцсон "Өв соёл ба цагаан сар - 2025" уулзалт, хэлэлцүүлэг хамтран зохион байгуулж ахмадууд болон төрийн байгууллагын 120 гаруй залуучууд, залуу гэр бүл, иргэд хамрагдсан. Ахмад настнаа хүндэтгэх, монгол өв соёл уламжлал, ёс заншлыг залуу хойч үед өвлүүлэхэд чиглэсэн 1 удаа контент нэвтрүүлэг бэлтгэн Орон нутгийн хэвлэл мэдээлэл 18 удаа мэдээлэл өгсөн байна Зууны мэдээ сонинтой хамтран ажиллаж, "Амьдралын тойрог нэвтрүүлэг 3 ахмад настанг оролцуулж Дарханы бүтээн байгуулалтад оролцож байсан 17 ахмад ярилцлага өгсөн. Дархан сумын 18 багт Ахмадуудын ХУРДАН клуб байгуулж ахмадуудад гар утасны хэрэглээ болон апплейкишн, E mongoli, пост машиныг ажиллуулах сургалт зохион байгуулж, багийн ахмадын зөвлөлийн дарга нар мэдээлэл зөвлөгөөг 174 гаруй ахмадад өгч ажиллаж байна.	100%
66	3.3.5.8.	Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Журам баталсан эсэх 2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/	Журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна.	Аймгийн ИТХ-ын 2024 оны 10 дугаар тогтоолыг үндэслэн Засаг даргын А/227 дугаар захирамжаар Эзэнгүй цогцос оршуулах зардалд 6,210,000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргасан.	6,210	ОНТ		100%

67	3.3.5.9.	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна." гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага д хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо	Суурь түвшний тоо	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Ахмадын хороотой хамтран Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-дх заалтын талаарх сурталчилгааг 91 төр болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагад суртчилан таниулахад 530 иргэн хамрагдаж, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар 16 удаа мэдээлэл өгсөн. Хуулийн этгээдийн дэргэдэх ахмадын хорооны тэргүүлэгчид нь 8 салбар хороонд хуваагдаж, байгууллага тус бүрээр хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр ажиллаж байна. Аймгийн Ахмадын хорооны байрны 3 тоот өрөөнд үйл ажиллагаагаа явуулж, ААНБ-уудын ахмадын хороотойгоо холбогдож, байгууллага ААН-ийн дэргэдэх нийт 68 ахмадын хороо, холбоо, зөвлөл тэдгээрт нийт 5460 гаруй ахмад настан хамрагдаж байна.				100%
68	3.3.5.10	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах.22.9.2.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо		Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгч болон хүүхдүүдэд гэрийн нөхцөлд, хөгжлийн онцлогт тохируулан хөдөлмөрт бэлтгэх, амьдрах дадалд сургах, гэр бүлийн орчинд хувь хүний амьдрах чадварыг нэмэгдүүлэх зорилготойгоор бие даан амьдрах өрөөг тохижуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Насанд хүрэгчдийг бие даан амьдрах өрөөгөөр /тевийн №111 тоот өрөөг/ дамжуулан өдөр тутамд хийгддэг энгийн дадалд сургадаг./Жишээлбэл: шүдээ угаах, хувцасаа эвхэх, гурил зуурч элдэх, төмс ногоо арилгах, угаалгын машин, зурагт ажиллуулж сурах гэх мэт/ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тоглоомын аргаар бие даан амьдрах дадалд суралцуулах зорилгоор төвийн №104 тоот өрөөг тохижуулсан. Мөн НҮБ-ийн хүүхдийн сангийн төслөөр 0-5 насны хүүхдийн хөгжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор усан заслын өрөө №124 тоот, эцэг эх асран хамгаалагч нарыг сургах, зорилгоор сургалтын өрөө №202 тоот зэргийг тохижуулаад байна."Шарын гол" ХК нийгмийн хариуцлагын хүрээнд тус сумын Ахмадын хорооны барилгын гадна болон дотор урсгал засварын ажилд 12,893,400 төгрөгний дэмжлэг, дулааны эрчим хүчний тоолуур суурилуулахад 6,352,813 төгрөгний дэмжлэг тус тус үзүүлсэн.				100%
НИЙТ											